# ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ГАЗАР НУТАГ ХӨВСГӨЛ НУУРЫН БЦГ-ЫН ЖАНХАЙН ДАВААНЫ АР НЭРТЭЙ ГАЗАРТ “БАМБАЙ СЕКЬЮРИТИ СЕРВИС” ХХК-НИЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ГРЭЙТ СИ ТУР” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БААЗ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар 2587394/

**Хянасан:**

Хөвсгөлийн УТХГХЗахиргааны Аялал жуулчлал, сургалт сурталчилгаа, орчны бүс хариуцсан ахлах мэргэжилтэн:............................................................/Б.Амартүвшин/

**Танилцсан:**

Хөвсгөлийн УТХГХЗахиргааны дарга:.................................................../Б.Батбилгүүн/

**Хэрэгжилтийг гаргасан:**

“Грэйт си тур” төслийн ерөнхий менежер.........................................../Д.Жамъянмядаг/

“Грэйт си ресорт” жуулчны баазын менежер:........................../Д.Дуламсүрэн/

**Улаанбаатар**

**2025 он**

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 3

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн ерөнхий мэдээлэл ........ 3

Төслийн танилцуулга ........ 4

Талбайн байршил ........ 13

Дэд бүтэц ........ 15

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ ........ 16

1.2 Газрын болон гадаргын усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ ........ 20

1.3 Хөрсний чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ ........ 23

1.4 Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ ........ 24

1.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ ........ 24

1.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ ........ 26

2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 28

3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 31

4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 32

5. ОРЧНЫ ХЯНАЛТ МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ........ 35

6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 37

7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ........ 41

# БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн ерөнхий мэдээлэл**

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

| № | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах багана |
|---|---|---|
| 1.1 | Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэр | “Бамбай секьюрити сервис” ХХК |
| | Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар | 9011317116 |
| | Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл | 1. Аялал жуулчлал<br>2. Гадаад худалдаа<br>3. Амралтын газар |
| | Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг | УБ хот, БЗД, 16-р хороо, 16-р хороолол, Улаанхуаран 32 тоот |
| | Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг | Гүйцэтгэх захирал: М.Сүхээ<br>Утас: 70166969<br>Цахим шуудан: Law@bambaisecurity.com |
| | Хариуцсан мэргэжилтэн, нэр, утас, цахим шуудан | Жуулчны баазын менежер: Д.Дуламсүрэн<br>Утас: 99188262<br>Цахим шуудан: dulamsuren03@yahoo.com |
| 1.2 | Төслийн нэр | “Грэйт си тур” аялал жуулчлал бааз |
| | Төслийн нэр харьяаллын байршил | Хөвсгөл аймгийн Алаг-эрдэнэ сум Хөвсгөл нуурын БЦГ-ын Жанхайн давааны ар |
| | Төслийн ангилал | Жуулчны бааз |
| | Төсөл эхэлсэн огноо | 2016 |
| | Ажилчдын тоо | 10 ажилтантай |
| | Төслийн хүчин чадал | Ээлжиндээ 80-100 хүн хүлээн авах хүчин чадалтай |

## Төслийн танилцуулга

“Грэйт си тур” аялал жуулчлал бааз төсөл нь 2016 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд Хөвсгөл нуур түүний ойр орчмын байгалийн үзэсгэлэнт газрууд болон дархад, цаатан зон олны зан заншлыг сонирхуулах, байгаль орчинд ээлтэй, байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг дээдлэн гадаад, дотоодын жуулчдыг хүлээн авч, зориулалтын хувцас хэрэгсэлтэй далайн гүний шумбалт хийж, хөвсгөл нуурын гүнд аялуулахаас гадна завь болон морин аялал зохион байгуулан аялагч, жуулчдад сонирхолтой, тав тухтай орчинг бий болгоход гол зорилго оршино.

## Жуулчны баазын барилга байгууламж

2016 оноос аялал жуулчлалын чиглэлээр 24 гэр, 2 байшин, 12 ханатай рестораны гэр, гал тогоо, ресепшн болон ариун цэврийн өрөө, душ, угаалгын өрөө, саун, усанд шумбалтын төв, 15 өрөө бүхий ажилчдын байр, 1 автомашины граж, 3 агуулах зэрэг барилга байгууламжтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн 60 хүний суудалтай усан онгоц, 2 аврах завь, 6 каяак завь, 6 хүний суудалтай шумбалтын завь, усан зогсоол зэрэг техник хэрэгсэлтэйгээс гадна 50 тонны бохир ус хадгалах цооног, хог ангилан ялгах хогны сав зэргийг тус тус байршуулсан.

Зураг 1



Жуулчны баазын чанх дээрээс харсан байдал

Зураг 2





Зочин хүлээж авах гэрүүд

Зураг 3







Зочин хүлээж авах 2 байшин

Зураг 4







Ресторaны 12 ханатай гэр

Зураг 5



Гал тогооны хэсэг

Зураг 6



Усанд шумбалтын төв болон харуулын байр

Зураг 7



Гүний шумбалт, аврах завь

Зураг 8




Ажилчдын байр

Зураг 9




Зочид угтах байр

Зураг 10





Усан онгоц, завьны зогсоол

Зураг 11



Ариун цэврийн өрөө, душ, саун, угаалгын өрөө

## Талбайн байршил

Жуулчны бааз нь Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Жанхайн давааны ард байрлана. Улаанбаатар хотоос хойш 676 км, Мөрөн хотоос баруун хойд зүгт 98 км, Хатгал тосгоноос 26 км зайд байршина.

Зураг 12



Зураг 13




Төсөл хэрэгжиж буй газрын сансрын зураг

Зураг 14



Төсөл хэрэгжиж буй орчны харагдах байдал

## Дэд бүтэц

**Дулаан хангамж:** Зочдын гэрүүд ердийн галлагаатай, зочдын 2 байшин цахилгаан халаалттай, ажилчдын байрыг нам даралтын зуухаар халаана.

**Зам харилцаа:** Улаанбаатар хотоос Хатгал тосгон хүртэл хатуу хучилттай автозам, Хатгал тосгоноос Жанхайн давааны ар хүртэл хатуу хучилттай автозамтай.

**Харилцаа холбоо:** Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр нь Хатгал тосгоноос 26 км зайд байрлах ба үүрэн телефоны бүх сүлжээ ашиглах боломжтой.

**Цэвэр ус:** Ундны усны болон ахуйн хэрэглээний усыг Хөвсгөл нуураас усны насосны тусламжтайгаар шууд татан авч хэрэглэдэг.

**Усан хангамж:** Усны насос болон усны тоолуур

**Хатуу хог хаягдал:** “Бор согоот” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хур хог хаягдал үүсгэхгүйгээр тогтмол тээвэрлүүлэн Хатгал тосгоны ландфиллын байгууламж руу татан зайлуулж байна.

# 1.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ /Хэмжих нэгж/ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| **1.1 Агаар** | | | | | |
| 1 | Тоосжилт, утаа, зохисгүй үнэр үүсэж тархан орчны агаарын чанарт нөлөөлөх | Тоосжилт үүсэх ямар нэгэн эх үүсвэр гаргахгүй байх, Тухайлбал, хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, төлөвлөгдөөгүй газарт нүх ухах зэрэг хөрсийг гэмтээх | Төсөл хэрэгжиж буй орчны агаар | Үйл ажиллагааны турш | Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хог хаягдлын сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор хогоо эх үүсвэр дээр нь шил, лааз, хуванцар, гялгар уут, бусад хаягдал гэсэн байдлаар ангилан ялгаж, зориулалтын саванд хаядаг ба хатуу хог хаягдлыг нийлүүлэх гэрээний дагуу Хатгал тосгоны ландфиллын байгууламжид нийлүүлдэг. /Зураг 15, 16, 17, 18/ |

Зураг 15

| | |
|---|---|
| БОР СОГООТ" ХХК-ИЙН<br>ЗАХИРАЛ<br>Ө.ДАВААБАЯР | "ГРЭЙТ СИ ТУР" ХХК<br>МЕНЕЖЕР<br>Д.ДУЛАМСҮРЭН |

**ХАТГАЛ ТОСГОНЫ ЛАНДФИЛЛЫН БАЙГУУЛАМЖИД ХАТУУ ХОГ ХАЯГДАЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Нэг талаас "Бор Согоот" ХХК-ийг төлөөлж захирал ажилтай Ө.Даваабаяр /цаашид ашиглагч гэх/ нөгөө талаас хэрэглэгчийг "Грэйт си тур" ХХК төлөөлж менежер ажилтай Д. Дуламсүрэн бид харилцан тохиролцож ангилсан хатуу хог хаягдлыг ландфиллын байгууламжид нийлүүлэх үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний төлбөр тооцооны харилцааг зохицуулахад оршино.

Гэрээний хугацаа: 2025 оны 06-р сарын 24-ны өдрөөс 2025 оны 10-р сарын 30-ны өдөр хүртэл.

**Хоёр.Ашиглагч байгуулагын эрх, үүрэг**

2.1 Хог хаягдлыг устгах" гэж хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор ландфилд булшлах, биологийн болон хими, физикийн аргаар боловсруулах, шатаах, халдваргүйжүүлэх, савлаж хадгалахыг эрх үүснэ.

2.2 Ашиглагч байгууллага хог хаягдлын тухай хуулийг мөрдөн ажиллана.

2.3 Ашиглагч хэрэглэгчээс ангилсан хог хаягдлыг хүлээн авна.

2.4 Ланфиллын байгууламжид шатах төрлийн аюултай хог хаягдал нийлүүлэхгүй байх үүрэгтэй./ үүнд халуун үнс нурам, төрөл бүрийн хийн газууд /

2.5 Хэрэглэгчээс ирсэн шатаах хувцас зөөлөн эдлэлийг шатаах зууханд хийж шатаах. Аюулгүй байдлыг хангаж ажиллана.

2.6 Хэрэглэгчид ланфиллын байгууламжид гал гаргах, согтууруулах зүйл хэрэглэхийг хатуу анхааруулах үүрэгтэй.

2.7 Тусгай хамгаалалтын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа жуулчны бааз нь ангилсан дахивар бүтээгдэхүүнүүдийг Тусгай хамгаалалтын газрын гаргасан цэгт нийлүүлнэ. Үүнд төрөл бүрийн шил хуванцар сав, төрөл бүрийн шилний төрөл орно.

2.8 Жуулчны бааз ангилаагүй хог хаягдал нийлүүлсэн тохиолдолд холбогдох гаазарт нь мэдэгдэнэ.

2.9 Ланфиллын байгууламжтай холбогдолтой санал гомдлыг ажлын цагаар диспечер 98941294, 99027221 дугаарын утсаар хүлээн авна

**Гурав. Хэрэглэгчийн эрх, үүрэг**

3.1 Хэрэглэгч хатуу хог хаягдлаа нийлүүлэхдээ жолоочийн дагалдах хуудас бөглөж илгээх.

3.2. Хэрэглэгч өөрийн хог хаягдлыг тухайн байгууламжид нийлүүлэхдээ дараах төрлөөр ангилж авчрах үүрэгтэй. /хавсралтаар/

3.3 Ландфиллын байгууламж нь ангилсан хатуу хог хаягдал нийлүүлнэ.

3.4 Хэрэглэгч хог хаягдлаа эх үүсвэр дээр ангилан ялгалт хийж тээвэрлэн авчирч нийлүүлэх эрхтэй.

3.5 Гэрээний 3.3 дах заалтыг мөрдөөгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авагдана.

3.6 Хэрэглэгч нь ландфиллын байгууламжид тавигдах шаардлага хангаагүйн улмаас ашиглагчдад хохирол учруулсан тохиолдолд үл маргах журмаар хохирлыг бүрэн барагдуулна.

3.7 Хэрэглэгч нь ашиглагч байгууллагатай зөвхөн ландфиллын байгууламжид ангилсан хатуу хог хаягдал нийлүүлэх гэрээг байгуулсан болно.

3.8. Хэрэглэгч нь гэрээ хийсэн тээврийн машинаар ачилт хийлгэж ландфилд хог нийлүүлнэ.

3.9 Хог хаягдал нийлүүлэхдээ тээврийн машин заавал хучлагтай байна.

**Дөрөв. Төлбөр тооцооны тухай**

4.1 Аймгийн Иргэдийн хурлын Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус хуралдааны 2025 оны 04 дүгээр сарын 11 өдрийн 45 дугаар тогтоолыг үндэслэн нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх , энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэг тарифийг мөрдөнө. Ангилсан хатуу хаягдлын үнэ буюу тариф 1 тн хог хаягдал 6013 төгрөг байна.

4.2.Хатуу хог хаягдлын төлбөрийг жингийн хэмжээний хуудсыг үндэслэн нэхэмжлэх ба нэхэмжлэлд заасан хугацаанд тээвэрлэгчийн Голомт банкны 4905109365 дугаарын харилцах дансанд төлж барагдуулна.

4.3 Төлбөрийг заасан хугацаанд барагдуулаагүй тохиолдолд иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6 дах заалтын дагуу төлбөл зохих төлбөрийн дүнгээс хоног тутамд 0,5%-иар алданги тооцно.

4.4 Хэрэглэгч нь сар бүр ашиглагчтай тооцоо тулгаж, үлдэгдлийн баталгаа хийнэ.

4.5 Үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт орсон тохиолдолд мөрдөж эхлэхээс 30 хоногийн өмнө хэрэглэгчид бичгээр болон утсаар мэдэгдэнэ.

**Тав. Гэрээ цуцлах тухай**

5.1.Доорхи тохиолдолд ашиглагч гарсан хохирлыг хэрэглэгчээр төлүүлэн гэрээг дангаар цуцлах эрхтэй.Үүнд:

-хатуу хог хаядлын төлбөрийг 3 удаа нэг сараас илүү хугацаагаар хожимдуулан төлөх

- хуульд болон гэрээнд заасан бусад нөхцөлийг зөрчих

5.2 Талууд гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох, өөрчлөлт оруулах тухай саналаа нөгөө талд 14 хоногоос доошгүй хоногийн өмнө мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ.Энэ хооронд нөгөө талаас хариу ирүүлээгүй нөхцөлд гэрээг дуусгавар болгож цуцалсанд тооцно.

**Зургаа. Бусад зүйл**

6.1.Гэрээтэй холбогдон гарсан аливаа асуудлыг хоёр тал эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх ба харилцан тохиролцоонд хүрээгүй асуудлыг хатуу хог хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

6.2.Гэрээг жил бүрийн эцэст хоёр тал харилцан дүгнэж цаашид гэрээг сунгах эсэх, хог хаягдлын нийлүүлэх явцад гарсан зөрчил харилцаатай холбоотой шинээр гарсан шийдвэр, хууль тогтоомжийн дагуу зарим заалтанд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг хэлэлцэн протокол үйлдэж байна.

6.3.Энэхүү гэрээнд заагдаагүй бусад асуудлыг энэ гэрээг байгуулах үед мөрдөж байсан Монгол улсын хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.

6.4. Энэхүү гэрээг 2025 оны 06-р сарын 24-ны өдөр Хатгал тосгонд Монгол хэл дээр хоёр эх хувь үйлдэж гарын үсэг зуран тээвэрлэгчид болон хэрэглэгчид нэг нэг хувийг өгөв.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
| "Бор Согоот" ХХК-ний<br>менежер У.Ариунаа<br>Утас: 99027221 | "Грейт си тур"ХХК жуулчны бааз<br>менежер Д. Дуламсүрэн<br>Утас:88013329 |
| РД: 4143515 | РД: 6258727 |

**Хатуу хог хаягдал ландфиллын байгууламж дээр авах хог хаягдлын төрлүүд**

- Кордон цаас, цаасны төрөл
- Төмрийн төрөл
- Ус ундааны сав, хуванцар
- Пиво ундаа болон бусад хөнгөн цагаан лааз
- Шил
- Модны төрөл
- Ахуйн газ, хийн төрлийн савнууд
- Гялгар уутнууд
- Малын баас
- Модны үртэс
- Мал амьны сэг зэм, үс ноос, арьс
- Хуванцарууд / хүүхдийн тоглоом, канистор/
- Шатаах зүйлүүд / гутал хувцас, даавууны зүйл/
- Барилгын хог хаягдал
- Өвс, зэрлэг ургамлын хог хаягдал
- Бусад хог хаягдал
- Дугуй болон хамер резин

**Аюултай хог хаягдал дотор**

- нүүрсний хаягдал шланк
- хуурай шингэн батерай
- эмийн зүйлүүд тариа
- Авто төрөл бүрийн шүүр

Зураг 16




Хог ачуулсны төлбөр төлсөн баримтууд

Зураг 17




Зураг 18





| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ /Хэмжих нэгж/ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| **1.2 Гадаргын болон газрын доорх ус** | | | | | |
| 1 | Ахуйн хог хаягдлыг ил задгай хаях, зориулалтын бус саванд хадгалах, ил задгай хаях зэргээс үер ус болон салхиар зөөгдөн гадаргын усыг бохирдуулах | -Хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогны савнуудыг хэрэгцээт газруудад байршуулах<br>-Тэмдэг, тэмдэглэгээ байршуулах | Орчны хөрс, гадаргын ус | Үйл ажиллагааны турш | Нуурын эрэг болон гэрүүд хооронд тагтай хогны савнуудыг байршуулсан нь ахуйн хог хаягдлыг ил задгай хаях, үер ус болон салхиар зөөгдөн гадаргын ус бохирдохоос сэргийлсэн. Мөн Алаг-эрдэнэ сумын Байгаль орчны байцаагчтай ус ашиглах гэрээ байгуулсан. /Зураг 18, 19/ / |
| 2 | Унд, ахуйн болон бусад хэрэгцээний усыг их хэмжээгээр замбараагүй хэрэглэх | Усыг ариг гамтай алдагдал багатайгаар хэрэглэх, анхааруулга, санамж байршуулах, тоолууржуулах | Газрын доорх ус | Үйл ажиллагааны турш | Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнээр ус ашиглуулах дүгнэлт 2024 онд гаргуулсан ба уг дүгнэлт нь гурван жилийн хугацаатай хийгдсэн, цэвэр ус ашигласны төлбөрийг төлсөн. Мөн усны нөөцийг хэмнэлттэй зарцуулах үүднээс LXS-32 загварын 2,5 м3/цаг хэмжих 32 мм голчтой усны тоолууртай. /Зураг 20, 21/ |

Зураг 19

2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А-367 дугаар тушаалын хавсралт

Батлав:Засаг дарга З.Ням-Очир

## УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 7 дугаар сарын 01 өдөр

Нэг. Ерөнхий зүйл:Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д -д заасны дагуу............ Сав газрын захиргаа, Хөвсгөл аймаг, Байгаль орчны газар/ 2024 оны 7 -р сарын 11 ны өдрийн ......... дугаартай ус ашиглуулах дүгнэлт................................. -ын олгосон/Сав газрын захиргаа, аймгийн Байгаль орчны газар, сум, дүүргийн Засаг дарга/20... оны 6 -р сарын 10 -ны өдрийн ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:Ус ашиглуулагчийг төлөөлж.Алаг-Эрдэнэ сум...................................................... Сав газрын захиргаа, аймаг,Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга, Ус хангагч байгууллагын..................................асуудал эрхэлсэн албан тушаалтан.......................... овогтой.........................................Ус ашиглагчийг төлөөлж Хөвсгөл аймаг, Алаг-Эрдэнэ.сум, ......... баг, улсын бүртгэл.............регистрийн дугаартай.................. иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ........................овогтой.......... нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1... жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2,1 Ус ашиглах зориулалт ...........22.Ашигпах усны хэмжээ: 2754
2.2.1.унд-ахуй, $m^3$/хоног..........2.2.үйлдвэрлэл, $m^3$/хоног....... 2.3.үйлчилгээ $m^3$/хоног 2754 2.4.эмчилгээ, сувилгаа, хүн/хоног 2.3.Усны чанар, найрлага.................2.4.Усны эх үүсвэрийн: Байршил ...........Солбицол X................................... Y............................................ Z.Барилга байгууламж...................................Тоног төхөөрөмжийн нэр, марк............................................Хүчин чадал.....................2.5.Хаягдал усны:Хэмжээ....................Стандартын шаардлага....................Хаях цэгийн байршил..........Солбицол X..... 50° 13' 09.78" Y 100° 06 46.05" ......... Z
2.6.Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.
Жинлэгдэх бодис:Органик бодис..... кг,Эрдэс бодис .......кг,Хүндметалл,......кг,Аюултай бохирдуулах бодис........гр. 2.7, Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин...........2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:..........................2.9.Усны тоолуурын::Төрөл, нэр, дугаар..........................
Загвар...............................Тоолуурын тоо.................................Суурилуулсан байгууллага, огноо......................
Баталгаажуулсан байгууллага, огноо.... ...............................Тоолуурын заалт....................................
2.10.Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ..... 248961...../ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ/
2.11 Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:...... 72968. ...../ус бохирдуулсны төлбөр/

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4 1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2.Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3.Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4.Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5.Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4 5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2.аль нэг тал татан буугдсан бол

4.6.Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж: ........................

Ус ашиглагчийг төлөөлж: ........................

GREAT SEA TOUR LLC

Зураг 20



Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2024 оны 07 сарын 22 өдрийн 379 тоот албан бичгийн хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2024 оны 07 дугаар Сарын 22-ны өдөр — Дугаар- ХөБО.2024/09 — Мөрөн

**1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар болон регистрийн дугаар:**

"Грэйт Си тур" ХХК
– Хөвсгөл аймаг Алаг-Эрдэнэ сум 4-р баг Баясгалан. Улсын бүртгэлийн дугаар: 1711010124, регистрын дугаар: 6258727 Утас: 99108268, 88013329 цахим хаяг: info@greatseatour.mn

**2. Төслийн нэр, байршил:** Хөвсгөл аймаг Алаг-Эрдэнэ сум Хөвсгөлийн байгалийн цогцолборт газар Жанхайн давааны ард байрлах "Грэйт Си Ресорт" аялал жуулчлалын бааз. Хөвсгөл нуур -Эгийн голын сав газарт хамаарна.

**3. Төсөл хэрэгжүүлэгч:** – Гүйцэтгэх захирал Ж.Бат-Эрдэнэ

**4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн хэмжээ, координат /Х,У/ :**
- Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах гэрчилгээ -2015/740 /2025 оны 12 сарын 22 өдөр хүртэл сунгасан./
- Талбайн хэмжээ 39456,28 квадрат метр

**5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:** Аялал жуулчлалын үйлчилгээ

**6. Үйлдвэрийн техник, технологи, ажиллах горим, хүчин чадал/ :**
"Грэйт Си Ресорт" аялал жуулчлалын бааз нь зуны 3 сар ажиллана.

**7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:**
"Грэйт Си Ресорт" жуулчны бааз нь 25 гэр, 2 байшин, 8 ханат гэр бүхий хоолны газар, нийтийн ариун цэврийн өрөө 4 кабинтай, шүршүүр 6 кабинтай, 6 хүний багтаамжтай цахилгаан халаагч бүхий саунтай ба нийт 100-120 хүн хүлээн авах хүчин чадалтай.

**8. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/ :**
Хөвсгөл нуураас усаа татан авч ашигладаг. 2 тн-ийн цэвэр усны нөөцийн савтай.



**9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, хэмжээ, хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/ :**
- Хөвсгөл нуураас татан авч ашигладаг.
- Ус дамжуулах шугам хоолойн урт 250 м, голч 32 мм;

**10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:**
- Хөвсгөл нуурын уснаас татан авч ашигладаг.
- Тоолууртай. LXS -32 загварын 2,5 м3/цаг хэмжих 32 мм голчтой тоолуурыг 2022 оны 07 сарын 21-нд суурилуулсан.

**11. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:**

- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол тайланг "Эко натур" ХХК-иар 2023 онд хийлгэсэн. 2023-2027 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах.

**12. Онцгой нөхцөл:**
- Усны нэвчилт шүүрэлтээс хамгаалах арга хэмжээ: Шугам хоолойн битүүмжлэлийг шалгаж ус нэвчих, бохирдох, алдагдахаас урьдчилан сэргийлэх, усыг хэмнэх, дахин ашиглах
- Хөрсний ус цэвдгээс хамгаалах арга хэмжээ: Шугам хоолойг хөлдөлтөөс хамгаалах
- Үерийн уснаас хамгаалах арга хэмжээ: Объектоо үерийн аюулаас хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хийх

**13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:**

- Усны зарцуулалтыг дүгнэлт эсвэл тоолуурын заалтаар тооцно
- Тоолуур ажиллаагүй нөхцөлд БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301-р тушаалын 14 дүгээр хавсралтын 22, 25 заалт, Засгийн газрын 2011 оны 302, 2013 оны 326, 327-р тогтоолын дагуу тооцно.

**14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийг урьдчилсан байдлаар тооцоход:**

- Хэрэглэсэн усыг Засгийн газрын 2011 оны 302, 2013 оны 326, 327-р тогтоолын дагуу тооцоход 1 шоо.метрийг /1507*0,6*10% =90.4/ 90.4 төгрөгөөр төлнө.
Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын усны экологи эдийн засгийн суурь үнэлгээ /гадаргын ус/ - 1507 төгрөг/шоо метр, ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр - 0.6, усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ -10%

Зураг 21



- БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301-р тушаалын 14-р хавсралтын 22, 25 дахь заалтыг үндэслэн тооцоход жуулчны баазын үйл ажиллагаанд 2754 шоо.метр ус ашиглана. /жуулчны бааз -120 хүн *180 л/хоног *90 хоног =1944 шоо метр, ресторан - 120*25*3*90=810 шоо метр нийт 2754/
- Усны нөөц ашигласны төлбөрийг тоолуурын заалтаар төлнө.

**15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:**
- Усыг бохирдохоос хамгаалах
- Усны нөөцийг хэмнэлттэй зарцуулах, хэмнэх
- Усыг эргүүлэн болон дахин ашиглах

**16. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө:**

- Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн "Усны тухай" хуулийн 28.6, 29.1-д заасны дагуу Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газраас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулж ажиллах
- Усны нөөц ашигласны төлбөрийг аймгийн ус рашааны нөөц ашигласны төлбөрийн Төрийн сан банк 100170000944 тоот дансанд төвлөрүүлэх /Тоолуур ажиллаагүй тохиолдолд дүгнэлтээр төлбөрийг тооцно/
- Ус ашиглах гэрээг жилийн эцсээр дүгнүүлж байх
- Усны дээжээ аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн лабораториор шинжлүүлж байх
- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах

ХЯНАСАН:
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА — П.МӨНХЖАРГАЛ

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН — Д.ДАМЦАГДУЛАМ

2754 * 90,4 =
248,9...



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УСНЫ ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ
№ 00225350

.................................................................-д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа LXS-32 загварын 2,5 м/ц хэмжих хязгаартай, 32 мм-ийн голчтой № 225350 –ын халуун, хүйтэн усны тоолуурыг № 78 лацаар битүүмжилж
(доогуур зурах)
2028 оны 07 -р сарын 21 –ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 0001 м³

Лабораторийн тэмдэг — Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2022.. оны 07 –р сарын 21.-ны өдөр

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ /Хэмжих нэгж/ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| **1.3 Хөрсөн бүрхэвч** | | | | | |
| 1 | Олон салаа зам гаргаснаас хөрс элэгдэж, эвдрэх | -Олон салаа зам гаргахыг хориглосон тэмдэг тавих<br>-Зураг төсөлд тусгаагүй газарт нүх ухах, барилга байгууламж барихыг хориглох | Орчны хөрс | Үйл ажиллагааны турш | 2025 онд шинээр барилга байгууламж барих буюу зураг төсөлд тусгагдаагүй газарт нүх ухаж, хөрсөн бүрхэвчийг гэмтээх газар шорооны ажил хийгдээгүй. |
| 2 | Ногоон байгууламжийн арчилгаа, мод сөөг тарьж ургуулах үедээ химийн бодис, бордоог зөвшөөрөлгүй хэрэглэснээр хөрс үржил шим алдах, бохирдох | Ногоон байгууламж, мод сөөг тарих, арчлах үед химийн бодис, бордоог хэрэглэхдээ мэргэжлийн зөвлөгөө авч, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | Орчны хөрс | Үйл ажиллагааны турш | Жуулчны баазын эзэмшил газрын хөрсийг байгалийн унаган төрхөөр нь хадгалж, хөрсийг бохирдуулах химийн бодис болон бордоог хэрэглээгүй болно. |

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ /Хэмжих нэгж/ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| **1.4 Газрын хэвлий** | | | | | |
| 1 | Барилга байгууламж барих үед газрын хэвлийд эвдрэл үүсэх | Санамж, анхааруулга байнга өгч байх, зураг төсөлд заагаагүй газарт нүх ухах | Газрын хэвлий гэмтэж, гуу жалга үүсэх | Үйл ажиллагааны турш | 2025 онд шинээр барилга байгууламж барих ажил хийгдээгүй учраас газрын хэвлий гэмтэж, эвдрэл үүсээгүй. |
| **1.5 Ургамлан нөмрөг** | | | | | |
| 1 | Хашаа дотор болон гадна талбайд зориулалтын замгүйгээс ургамлан нөмрөг устах, гэмтэх | Зориулалтын хайрган, чулуун болон хатуу хучилттай зам барих, элэгдэлд орсон, доройтсон газрыг байнга тордох, сэргээх, мод, бут тарих, ургамалжуулах | Эзэмшил газрын хүрээнд | Үйл ажиллагааны турш | Ургамлан нөмрөг гэмтэхээс сэргийлж эзэмшил газрын хүрээнд гэрүүдийн хооронд болон ресторан хүрэх замыг байгалийн чулуугаар хийсэн. Мөн хашааны хаалганаас зогсоол хүрэх замыг сайжруулсан шороон зам болгосон. /Зураг 22/ |

Зураг 22









| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ /Хэмжих нэгж/ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| **1.6 Амьтны аймаг** | | | | | |
| 1 | Мал амьтан ил задгай хаясан хог хаягдал болон бохирдсон өвс, ургамлыг идэж хордох | -Мал амьтан идэхээс сэргийлж ялзарч муудаж болзошгүй хүнсний зүйл, хоол хүнсний үлдэгдлийг ил задгай хаяхгүй байх, анхааруулга, санамж байршуулах | Төсөл хэрэгжиж буй орчинд байрлаж болох мал амьтан | Үйл ажиллагааны турш | Бэлчээрлэж буй мал болон ан амьтан ил задгай хаясан хог хаягдал болон бохирдсон өвс, ургамлыг идэж, хордохоос сэргийлэн зориулалтын хогны савнуудыг гэрүүдийн дунд болон ресторан, нуурын эрэг, ариун цэврийн байгууламжийн хажууд байршуулсан. Мөн нуурын эрэг, баазын нийт талбайн хог хаягдлыг хуваарийн дагуу түүж, ангилан ялгаж, зориулалтын хогны саванд хийж, ачуулдаг. /Зураг 23/ |

Зураг 23









# 2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Тоо хэмжээ /Хэмжих нэгж/ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төслийн обьектийн орчныг тохижуулах | Эзэмшил газарт шинээр тохижилт хийх, орчныг сайжруулах | Төсөл хэрэгжиж буй орчин | Үйл ажиллагааны турш | Амрагчдын ая тухтай байдлыг хангах болон баазын орчныг тохижуулах зорилгоор баазын хашааны орох хаалгыг шинээр хийж гүйцэтгэсэн. Машин орох хаалганы өргөн нь 5 м 20 см, өндөр нь 2 м, явган хүний хаалганы өргөн нь 1 м, өндөр нь 2 м хэмжээтэйгээр тус тус хийгдсэн. /Зураг 24/ |
| 2 | Орчны ая тухтай нөхцөлийг бүрдүүлж, хүлэмжийн хийн /CO2/ ялгаралтыг бууруулах | Цэцэрлэгжүүлэх, цэцгийн мандалургуулах, зүлэгжүүлэх | 150 м² талбайг зүлэгжүүлэх | Үйл ажиллагааны турш | Дугуйн зогсоолын орчмын 130 м² талбайг зүлэгжүүлсэн. /Зураг 25/ |

Зураг 24



Хуучин байсан хаалга



Шинээр барьсан хаалга

Зураг 25





# 3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Тоо хэмжээ /Хэмжих нэгж/ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төслийн үйл ажиллагаа эхлэн газар шорооны ажил хийгдэх үед түүх, соёлын өв, эд зүйлс хөндөгдөж болзошгүй | Түүх, соёлын эд зүйл илэрсэн тохиолдолд ажлаа нэн даруй зогсоож, хамгаалалт хийж, харьяа дээд шатны засаг захиргааны болон мэргэжлийн байгууллагад мэдэгдэнэ. | - | - | Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн газрын судалгааны явцад түүх, соёлын өв, дурсгалт зүйл бүртгэгдээгүй. |

# 4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Тоо хэмжээ /Хэмжих нэгж/ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн хатуу хог хаягдал, тогтмол хугацаанд зайлуулаагүйгээс агаар, хөрс, усыг бохирдуулах, сөрөг нөлөөлөл учруулах | -Хатуу хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогны савнуудыг байршуулах<br>-Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг эрх бүхий байгууллагад хүргэж өгөх<br>-Ахуйн шингэн бохирыг төвийн нэгдсэн шугаманд нийлүүлж, төлбөр төлөх гэрээтэй байх | Ашиглаж буй талбайн орчин | Үйл ажиллагааны турш | Хатгал тосгоны ландфиллын байгууламжид хатуу хог хаягдал нийлүүлэх гэрээ, “Бор согоот” ХХК-тай бохир ус нийлүүлэх гэрээг тус тус байгуулсан ба гэрээний дагуу хатуу хог хаягдал болон ахуйн шингэн бохирыг төлбөр төлөн тээвэрлүүлж, нийлүүлдэг. /Зураг 26, 27/ / |

Зураг 26

БАТЛАВ
"БОР СОГООТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
................ Ө.ДАВААБАЯР

БАТЛАВ
"ГРЭЙТ СИ ТУР" ХХК
МЕНЕЖЕР
................ Д.ДУЛАМСҮРЭН

**БОХИР УС НИЙЛҮҮЛЭЛТИЙН ГЭРЭЭ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Нэг талаас "Бор Согоот" ХХК-ийг төлөөлж захирал ажилтай Ө. Даваабаяр /цаашид ашиглагч гэх/ нөгөө талаас "Грэйт Си Тур" ХХК хэрэглэгчийг төлөөлж захирал ажилтай Д. Дуламсүрэн бид харилцан тохиролцож тусгай зориулалтын машинаар бохир усыг татан авчирсан бохир усыг цэвэрлэх байгууламжид нийлүүлэх , үйлчилгээний төлбөр тооцооны харилцааг зохицуулахад оршино.

Гэрээний хугацаа: 2025 оны 06-р сарын 24-ны өдрөөс 2025 оны 10-р сарын 30-ний өдөр хүртэл.

**Хоёр.Ашиглагчийн эрх, үүрэг**

2.1 Ашиглагч нь хэрэглэгчийн бохир усны цооногт тавигдах шаардлага, өөх тос элс баригч суурилуулан хангасан тохиолдолд гэрээ байгуулснаар бохир усаа нийлүүлэх эрх үүснэ.

2.2 Ашиглагач нь хэрэглэгчийн хүсэлтээр тээвэрлэн ирсэн бохир усыг цэвэрлэх байгууламжид нийлүүлнэ.

2.3 Хэрэглэгч нь захиалга хожимдож өгсөн буюу цооног дүүрч хальсан үед дуудлага өгсний улмаас ямар нэгэн асуудал үүссэн тохиолдолд ашиглагч хариуцлага хүлээхгүй.

2.4 Хот суурингийн усан хангамж ариутгах татуурга ашиглалтын хуулийн дагуу бохир ус тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй машин механизмаар тээвэр хийлгүүлнэ.

2.5 Ашиглагч цэвэрлэх байгууламжийн технологийн горимыг мөрдүүлэхийн тул MNS6561:2015 стандартын бохир усыг хүлээж авах болно.

2.6 Ашиглагч нь тээвэрлэгдэн ирж байгаа тухайн газрын бохир усыг шинжилгээнд хамруулж стандартын ус хүлээн авах болно.

2.7 Хэрэглэгч нь бохир ус нийлүүлсэн зардлыг гэрээнд заасны дагуу төлж барагдуулна.

2.8 Хэрэглэгчийн бохир усыг тээвэрлэн ирж байгаа тусгай зөвшөөрөлтэй жолооч согтуу ирсэн тохиолдолд цагдаад мэдэгдэж бохир усыг нийлүүлэхгүй арга хэмжээ авах болно.

2.9 Бохир ус нийлүүлэх захиалгыг цэвэрлэх байгууламжийн диспечерийн утсанд 24 цагийн өмнө 98941294, 99027221, 99121294, 88214685 дугаарын утсанд мэдэгдэнэ.

2.10 Өөх тос баригч суурилуулсан газраас бохир ус нийлүүлнэ.

**Гурав. Хэрэглэгчийн эрх, үүрэг**

3.1 Хэрэглэгч нь гэрээ байгуулсан өдрөөс эхлэн бохир усаа татуулан нийлүүлэх эрхтэй.

3.2 Нийлүүлэх бохир усны захиалгыг 24 цагийн өмнө ашиглагч байгууллагад мэдэгдсэн байна.

3.3 Хэрэглэгчийн бохир усны цооног нь Байгаль орчны сайд, сангийн сайдын хамтарсан 1995 оны 169/170 тоот тушаалын хавсралт бохир ус хаях цооногийг доторлож ашиглах журмын дагуу хийгдсэн байна.

3.4 SPR технологийн цэвэрлэх байгууламж тул MNS6561:2015 стандартын дагуу бохир усыг нийлүүлэх

3.5 Хэрэглэгч цооног графикт хугацаанаас өмнө бохир усны цооногийн багтаамжийн 70-80% дүүрсэн үед бохир усаа татуулах

3.6 Гэрээний 3.3 дах заалтыг мөрдөөгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авагдана.

3.7 Хэрэглэгч нь бохир усыг татуулахдаа жолоочийн хяналтын хуудсыг үнэн зөв бөглөж гарын үсэг зурж баталгаажуулна. Жолоочийн дагалдах хуудсыг хянаж шалгаагүй гарын үсэг зурж баталгаажуулсан хариуцлагыг ашиглагч хариуцахгүй.

3.8 Хэрэглэгч нь бохир усны цооногт тавигдах шаардлага хангаагүйн улмаас ашиглагч байгууллагад хохирол учруулсан тохиолдолд үл маргах журмаар хохирлыг бүрэн барагдуулна.

3.10 Хэрэглэгч өөрийн хүчин чадалд нийцсэн өөх тос баригч суурилуусан байх.

**Дөрөв. Төлбөр тооцооны тухай**

4.1 Цэвэрлэх байгууламжид нийлүүлэх бохир усны зардал 1тн бохир төгрөг 13750 /НӨАТ-тай/

4.2.Бохир ус тээвэрлэн ирсэн машиныг жинлэж төлбөрийг нэхэмжлэх ба нэхэмжлэлд заасан хугацаанд ашиглагчийн Голомт банкны 4905109365 дугаарын харилцах дансанд болон бэлнээр төлж барагдуулна.

4.4 Төлбөрийг заасан хугацаанд барагдуулаагүй тохиолдолд иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6 дах заалтын дагуу төлбөл зохих төлбөрийн дүнгээс хоног тутамд 0,5%-иар алданги тооцно.

4.4 Хэрэглэгч нь улирал бүр ашиглагчтай тооцоо тулгаж, үлдэгдлийн баталгаа хийнэ.

4.5 Үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт орсон тохиолдолд мөрдөж эхлэхээс 30 хоногийн өмнө хэрэглэгчид бичгээр болон утсаар мэдэгдэнэ.

**Тав. Гэрээ цуцлах тухай**

5.1 Доорхи тохиолдолд ашиглагчид гарсан хохирлыг хэрэглэгчээр төлүүлэн гэрээг дангаар цуцлах эрхтэй.Үүнд:

Бохир ус тээвэрлэн ирж байгаа тусгай зөвшөөрөлтэй машин зөвхөн тухайн газрын бохир усыг өөрийн тээвэрлэн нийлүүлнэ.

- төлбөрөө нэг сараас илүү хугацаагаар хожимдуулан төлөх
- Нийлүүлж байгаа бохир нь цэвэрлэх байгууламжийн бактери үхүүлсэн тохиолдолд гарах зардлыг бүрэн төлүүлж холбогдох байгууллагад мэдэгдэнэ.
- тоног төхөөрөмжинд гэмтэл учруулсан
- ·хуульд болон гэрээнд заасан бусад нөхцөлийг зөрчих

5.2 Талууд гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох, өөрчлөлт оруулах тухай саналаа нөгөө талд 14 хоногоос доошгүй хоногийн өмнө мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ.Энэ хооронд нөгөө талаас хариу ирүүлээгүй нөхцөлд гэрээг дуусгавар болгож цуцалсанд тооцно.

**Зургаа. Бусад зүйл**

6.1.Гэрээтэй холбогдон гарсан аливаа асуудлыг хоёр тал эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх ба харилцан тохиролцоонд хүрээгүй асуудлыг ХСУХАТАҮЗЗ-ийн баталсан дүрмийн дагуу шийдвэрлүүлнэ.

6.2.Гэрээг жил бүрийн эцэст хоёр тал харилцан дүгнэж цаашид гэрээг сунгах эсэх, бохир ус тээврийн харилцаатай холбоотой шинээр гарсан шийдвэр, хууль тогтоомжийн дагуу зарим заалтанд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг хэлэлцэн протокол үйлдэж байна.

6.3.Энэхүү гэрээнд заагдаагүй бусад асуудлыг энэ гэрээг байгуулах үед мөрдөж байсан Монгол улсын хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.

6.4 Гэрээний хавсралт нь гэрээний адил хүчин төгөлдөр байна.

6.5 Бохир ус нийлүүлэх үнэ тарифид өөрчлөлт орсон тухайн үед нь гэрээнд өөрчлөлт оруулна.

6.6 Энэхүү гэрээг 2025 оны 06 -р сарын 24-ний өдөр Хатгал тосгонд Монгол хэл дээр хоёр эх хувь үйлдэж гарын үсэг зуран тээвэрлэгчид болон хэрэглэгчид нэг нэг хувийг өгөв.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| "Бор Согоот" ХХК-ний | " Грэйт Си Тур"ХХК |
| Инженер Д.Одбаатар | Менежер Д. Дуламсүрэн |
| Утас: 89833344, 99027721 | Утас:88013329 |
| РД:4143515 | РД: 6258727 |

Зураг 27







# 5. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо | Бохир шингэн дамжуулах шугам орчимд | Хагас жилд | Жуулчны бааз орчмын хөрс болон уснаас нян судлалын шинжилгээ авсан бөгөөд шнижилгээний дүнгийн тухай “Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа”-ны судалгаа шинжилгээ, байгалийн нөөц, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн дүгнэлт гаргасан. Мөн баазын ариун цэврийн байгууламж болон гал тогоо, ажилчдын байранд Хөвсгөл аймгийн ахуйн хортон, шавьж устгал, ариутгал халдваргүйтгэлийн “Ган-Өрлөг” ХХК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр ариутгал халдваргүйтгэл хийлгэж, үйлчилгээний төлбөрт 112,200 төгрөг төлсөн. /Зураг 28/ |
| 2 | Ундны усан дах эмгэг төрүүлэгч бактерийн тоо<br>-Усны чанар: pH, ууссан нийт давс | Цэвэр усны нэгдсэн системийн эх үүсвэр | Хагас жилд | |
| 3 | Ундны усны бүрэн шинжилгээ. Нийт хатуулаг: ($CaCO_3$), Ca, Mg, Na, K, $NO_3$, $NH_4$, As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрс устөрөгчид | Үндсэн шугамаас | Хагас жилд | |

Зураг 28



ХӨВСГӨЛИЙН УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮНГИЙН ТУХАЙ

2025.01.06 Хатгал

Хөвсгөлийн УТХГ-ын даргын баталсан 2024/0805 дугаар Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүс газруудын ундны ус, хөрсний нянгийн мониторинг судалгаа ажил хийх удирдамжийн дагуу Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын 24 цэгийн дээжийг авч Хөвсгөл аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн дэргэдэх Эрүүл ахуйн нян судлалын хяналтын лабораторийн нян судлалын шинжилгээнд 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдөр хамрууллаа.

Лаборторын 686 тоот сорилын дүнгээр:
Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч “Грэйт-Си-Тур” жуулчны баазын 1-р цэгийн ус нь нян судлалын шинжилгээгээр ББЕТ 0,1мл-д 100-аас их ш, E-coli /гэдэсний савханцар/ 100 мл-т илэрсэн, salmonella spp /нянгийн гаралтай гэдэсний цочмог/ 25 мл-т илрээгүй.

Лаборторын 687 тоот сорилын дүнгээр:
Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч “Грэйт-Си-Тур” жуулчны баазын 2-р цэг ариун цэврийн байгууламж орчмын хөрс нян судлалын шинжилгээгээр Clostridium perfringens 0.1гр-д илрэв, гэдэсний бүлгийн нян 0.1гр-д илрэв, salmonella spp 1гр-д илрээгүй.

Дээрх байдлаас ДҮГНЭХ НЬ:

“Грэйт-Си-Тур” жуулчны бааз орчмын 1-р цэгийн ус нь Монгол улсад мөрдөгдөж буй Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 1997 оны 143/А/352 дугаар Гадаргын усны цэврийн зэргийн ангиллын нормын Усны чанарын ангиллын нормын бохирдолтой усанд хамаарч байна.

“Грэйт-Си-Тур” жуулчны бааз орчмын 2-р цэгийн хөрснөөс гэдэсний бүлгийн нян, Clostridium perfringens илэрсэн нь хөрс бохирдож буйг илтгэж байна.

Иймд хөрсний бохирдлыг бууруулахад эрүүл ахуйн шаардлага хангасан нийтийн бие засах газрыг сайжруулах, зориулалтын хогийн савыг хүртээмжтэй, хэрэгцээтэй газар зөв байрлуулах, ногоон байгууламж нэмэх, гүний хөрсийг шинжилгээнд хамруулан ажиллах шаардлагатай.

**Дүгнэлт бичсэн:**

Судалгаа шинжилгээ, байгалийн нөөц,
мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Э.Амарзаяа



БАТЛАВ
ГАН-ӨРЛӨГ ХХК-НЫ
ЗАХИРАЛ (Б.ЭРДЭНЭДАЛАЙ)

БАТЛАВ
Грейт си тур ХХК-НЫ
ЗАХИРАЛ

АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ, ШАВЬЖГҮЙЖҮҮЛЭЛТ, МЭРЭГЧГҮЙТГЭЛ ХИЙХ, АХУЙН ШАВЬЖ, МЭРЭГЧ УСТГАХ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БОДИС НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2025 оны 07 сарын 02 өдөр № 2025/86 Мөрөн

Нэг талаас Грейт Сее тур ХХК (Цаашид **“ЗАХИАЛАГЧ”** гэх), нөгөө талаас **“ГАН-ӨРЛӨГ” ХХК** (цаашид **“ГҮЙЦЭТГЭГЧ”** гэх) нь шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэл, ариутгал халдваргүйтгэл хийх болон ариутгал халдваргүйтгэлийн бодис нийлүүлэхээр харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

**НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО**

Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд стандартын шаардлага хангасан техник, технологийн дагуу шавьж, мэрэгч устгах, ариутгал халдваргүйжүүлэлтийн үйлчилгээг үзүүлэх, халдварт өвчний гаралтыг бууруулах, шавьж, мэрэгчийн тархалтыг багасгах, хүний ая тухтай ажиллах, амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой.

**ХОЁР: ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ:**

2.1. Үйлчилгээний захиалгыг **биеэр** болон **утсаар хүлээн** авна.

2.2. Ариутгал, халдваргүйтгэл, шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийн үйлчилгээг олон улсын стандартын шаардлагад нийцсэн, Монгол улсын нутаг дэвсгэрт тухайн жилд ашиглаж болох бодисын жагсаалтад бүртгэгдсэн хор бодисоор технологи зааврын дагуу чанартай хийж гүйцэтгэх ба тухайн жагсаалтад бүртгэгдсэн лабораторийн шинжилгээнд хамрагдсан, хүчинтэй хугацаатай хор бодисыг хэрэглэх заавар дагалдах баримт бичгийн хамт нийлүүлнэ.

2.3.Үйлчлүүлэгч талын мэргэжилтний хамт үйлчилгээ хийлгэх өрөө тасалгааны тоо, талбайн хэмжээг тооцон гаргана.

2.4.Үйлчилгээнд хэрэглэх хор бодисын онцлог, аюулгүй ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгч, үйлчилгээ хийх өдөр, цаг давтамжийг тогтоож, үйлчилгээний төлбөрийг тогтооно.

2.5.Үйлчилгээнээс хойш байгууллагын сандартад заасан хугацаанд эргэн тандалт хийж цаашид авах арга хэмжээг төлөвлөнө.

2.6. Үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулахыг шаардах

2.7.Гэрээг үндэслэн ариутгал, халдваргүйжүүлэлт, шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэл хийх мэдэгдлийг 1-7 хоногийн өмнө үйлчлүүлэгч байгууллагад мэдэгдэж, урьдчилсан бэлтгэлийг хангасан байхыг зөвлөнө.

**ГУРАВ. ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА, ИРГЭНИЙ ҮҮРЭГ:**

3.1. Үйлчилгээний захиалгыг утсаар болон биеэр очиж өгнө.

3.2.Үйлчилгээ хийлгэх газрын өрөө тасалгааны тоо, талбайн хэмжээг танилцуулж, үйлчлүүлэх талбай, үйлчилгээний төрөл, давтамжийг тогтооно.

3.3.Гүйцэтгэгч талд тухайн байгууллагад халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн эсэх, шавьж, мэрэгчийн тархалт, төрөл зүйлийн талаар үнэн зөв бодит мэдээлэл өгнө.

2025 он



3.4.Гүйцэтгэгч байгууллагаас өгсөн үйлчилгээний өмнө болон дараа баримтлах зааврыг чанд мөрдөж ажиллана.

3.5.Үйлчилгээний явц болон хэрэглэж буй хор бодисын чанарт хяналт тавина.

3.6. Үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь барагдуулна.

3.7.Байгууллагын нийт ажилчид үйлчилгээнд хэрэглэсэн хор бодис, өгөөштэй болгоомжтой харьцах, үйлчилгээ хийсэн талын мэргэжилтний заавар зөвлөмжийг чанд сахиж хэрэгжүүлэх ажлыг тухайн байгууллагын эмч, менежер, холбогдох хүмүүс зохион байгуулна.

3.8.Үйлчилгээ хийсэн өдрөөс эхлэн өгш, хор бодисыг буцаан цуглуулах хүртэл хугацаанд хэрэглэсэн хор бодис, өгшийн хадгалалт, хамгаалалт түүнтэй холбогдон гарах хариуцлагыг бүрэн хариуцна.

3.9.Захиалагч байгууллага нь захиалга өгөх үед 50 хувийг урьдчилан төлж, үйлчилгээг хийлгэсний дараа үлдсэн 50 хувийг бэлнээр болон 3 хоногийн дотор **ХААН** банкин дахь Ган-өрлөг ХХК-ны **5890649941** тоот дансанд төлбөрийг хийнэ. Иргэн нь үйлчилгээний дараа төлбөрийн шууд төлнө.

3.10.Энэхүү гэрээнд заасны дагуу захиалагч тал үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд үнийн дүнгийн 0.2 хувиар алданги тооцож төлнө.

**ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ҮНЭ ТАРИФ**

4.1.**2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс 2027 оны 07 дугаар сарын 02-ны өдөр хүртэл-“ХОЁР”** жилийн хугацаатай байгуулав.

4.2.Гэрээнд оролцогч талууд шаардлагатай гэж үзвэл харилцан зөвшилцөж тохиролцсоны дараа гэрээнд нэмэлт өөрчлөлтийг бичгээр хийж болно.

4.3. Энэхүү гэрээг хугацаа дуусахаас нэг сарын өмнө сунгах, эсвэл хугацаанаас өмнө цуцлахаар бол саналыг бичгээр мэдэгдэнэ.

4.5. Ариутгал, халдваргүйжүүлэлт (**1м²** талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл хийх бодисын нэр төрлөөс хамаарч **1000** төгрөгөөр тооцно.)

✓ Болзошгүй аюул гамшиг, халдварт өвчин голомтлон гарсан үед гэрээ, тарифын дагуу дуудлагаар хийнэ.

✓ Хавар, намрын улиралд эдэлбэр газрын хөрсөнд халдваргүйжүүлэлт хийнэ.

4.6.Шавьжгүйтгэл (мэрэгчгүйтгэл)-ийг (**1м²** талбайд **1000** төгрөгөөр тооцно) аж ахуйн нэгж, байгууллага, орон сууц, байшингийн подвaль, үүдний хэсэг, сантехникийн шугам хоолойны хэсэг, шатны хонгил гэх мэт хэсгүүдэд хийнэ.)

Ариутгал халдваргүйтгэл, шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийг хавар, намар буюу жилд 2 удаа хийнэ. Шаардлагатай тохиолдолд нэмэлт захиалгаар хийлгэж болно.

**ТАВ. БУСАД**

5.1. Гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөржинө. Гэрээг 2 хувь үйлдэж талууд нэг нэг хувийг эзэмших ба эх хувиуд нь адил хүчинтэй байна. Гэрээг засварлах, хуурамчаар үйлдэхийг хориглоно. Гэрээнд заагдсан хүчинтэй хугацаа дуусмагц уг гэрээ хүчингүйд тооцогдоно.

5.2.Үйлчилгээний чанартай холбогдон гарсан гомдлыг 2 тал шалтгаан нөхцлийг тогтоон хамтран шийдвэрлэнэ. Харилцан тохирч шийдвэрлэх боломжгүй бол хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж: | Захиалагч байгууллагыг төлөөлж: |
|---|---|
| ГАН-ӨРЛӨГ ХХК-ны | Грейт си тур ХХК-НЫ |
| Захирал (Б.Эрдэнэдалай) | ЗАХИРАЛ |
| Регистрийн дугаар 4123298 | Регистрийн дугаар: 6258727 |
| Утас: 99660960, 88836110 | Утас: |
| Хаяг: Хөвсгөл аймгийн сумын 8-р баг | Хаяг: Хөвсгөл аймгийн Хатгал |

25/86

2025 он



НХМаягт МХ3

Сангийн, эдийн засгийн сайд
Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны
6-р сарын 18-ны 171/111 тоот тушаалын хавсралт

БЭЛЭН МӨНГӨНИЙ ОРЛОГЫН БАРИМТ

Дугаар ... он ... сар ... өдөр

Байгууллагын нэр ... Ган-Өрлөг ХХК
Хүлээн авагч ... овогтой ...
Үнэмлэх /паспорт/-ийн дугаар ...
Гүйлгээний утга ...
...
...
Олгосон мөнгөний дүн ... төгрөг ... мөнгө
...
/үсгээр/
Хавсарсан баримт ...

Тэмдэг
Дарга .../...
Нягтлан бодогч .../...
Олгосон нярав .../...
Мөнгө тушаагч .../...

# 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Хэрэгжүүлэх хуваарь | Хариуцсан албан тушаалтан | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчныг хамгаалах асуудлаар жилийн ажлын тайлангаа тогтоосон хугацаанд нь гаргаж өгч, холбогдох дээд шатны байгууллагуудтай хамтран ажилллах | 4-11-р сар | “Бамбай секьюрити сервис” ХХК | 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн тайланг гаргасан. Мөн Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах гурвалсан гэрээг таван жилийн хугацаатай байгуулсан ба гэрээний хугацаа 2027 он хүртэл хүчинтэй. Мөн газар ашиглах гэрээг Хөвсгөлийн УТХГХЗ-тай 2025 оны 1-р сард дүгнүүлсэн ба 2026 оны 1-р сард журмын дагуу дүгнүүлнэ. /Зураг 29, 30, 31/ |
| 2 | Байгаль орчны аудитыг 2 жил тутам хийлгэх | - | “Бамбай секьюрити сервис” ХХК | Байгаль орчны аудитыг 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө оруулсан бөгөөд 2025 онд багтаан хийлгэнэ. |

Зураг 29

2018 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн
10/7680 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

БАТЛАВ: ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ
БҮС НУТГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.БАТМӨНХ
2022.10.11

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ
ГАЗАР АШИГЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

**2022 оны 07 дугаар сарын 22-ний өдөр** **№ 2022/008**

Монгол Улсын "Газрын тухай" хуулийн 34 дугаар зүйл, "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулийн 33 дугаар зүйлийн 1.36 дугаар зүйлийн 1.37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтуудыг үндэслэн:

Нэг талаас **Алаг-Эрдэнэ сум**, Засаг даргыг төлөөлж **З.Ням-Очир**, Хөвсгөлийн Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны даргыг төлөөлж **Г.Энхбаяр** цаашид "газар ашиглуулагч" гэх,

Нөгөө талаас аж ахуйн нэгж **"Бамбай секьюрити" ХХК-ны захирал П.Мягмарсүрэн** цаашид "газар ашиглагч" гэх бид Алаг-Эрдэнэ сумын нутагт орших Хөвсгөлийн Байгалийн Цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд орших **Жанхайн давааны ард** нэртэй газрыг аялал жуулчлалын зорилгоор ашиглах тухай (энэхүү) гэрээг байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Энэхүү гэрээнд салшгүй хэсэг болох дараахь зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно.

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын **2015** оны **А/27** дугаар тушаалын хуулбар.
2. Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын **2016** оны **01** дүгээр сарын **15**-ны өдөр олгосон Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах **2015/740** тоот гэрчилгээ, хавсралт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын **2021 оны 11 дүгээр сарын 17-ны 17-ны өдрийн А/368 тушаал**ыг үндэслэн хийгдсэн 2015/740 тоот гэрчилгээний сунгалтын хуулбар, БОАЖ-ын сайдын **2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/341 дүгээр тушаал**аар талбайн хэмжээнд өөрчлөлт оруулсан гэрчилгээний хуулбар.
3. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг, эргэлтийн цэгийг
4. Газрын төлөв байдлын тухай мэдээлэл: Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний дүгнэлт
5. Хамгаалалтын захиргаанаас газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт
6. Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлсан журмын дагуу газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгүүлж баталгаажуулсан баримт.
7. Хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөөнд нийцсэн төсөл.
8. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.
9. Тухайн жилд батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө.

4. Газар ашиглах эрх хүчингүй болсон, гэрээний хугацаа дуусгавар болоход газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг Газрын тухай хуулийн 47 болон 49 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

**Гэрээ байгуулсан:**
**Газар ашиглуулагч**

Хөвсгөлийн УТХГ-ын
хамгаалалтын Захиргааны
Дарга........ Г.Энхбаяр
Хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 11-р хороо, 31-р гудамж, 3 тоот
Утас: 9999-2895

Хөвсгөл аймгийн
Алаг-Эрдэнэ Сумын
Засаг дарга.................З.Ням-Очир
Хаяг: Алаг-Эрдэнэ сум
Утас: 98381616

**Газар ашиглагч**
Бамбай секюрити сервис ХХК
Захирал:.....................М.Сүхээ

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
16-р хороолол, Улаанхуаран, 32 тоот

Утас:9411-0097

Зураг 30

ХӨВСГӨЛИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАРТ ГАЗАР АШИГЛАГЧ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР АШИГЛАХ ГЭРЭЭГ ДҮГНЭХ

№ 03

Гэрээ дүгнэсэн огноо:2025-01-06

Нэгж талбарын дугаар: 6714003741

1. Гэрээ дүгнүүлэх иргэн, ААН мэдээлэл

| Иргэн, ААН байгууллага | | | |
|---|---|---|---|
| Оноосон нэр | Регистрийн дугаар | Газрын гэрээний дугаар | Газар ашиглах гэрчилгээний дугаар |
| "Бамбай секьюрити сервис" ХХК | 2587394 | 2022/008 | 2015/740 |
| Газрын байршил: | | | Газар ашигладаг эсэх |
| Жанхайн давааны ард | | | Тийм |
| Газрын хэмжээ га, м$^2$ | Газрын төлбөрийн хэмжээ /төг/ | Зориулалт | Газар ашиглах хугацаа |
| 39459.28 м$^2$ | 591,692 төг | Аялал жуулчлал үйлчилгээ | 2025-12-22 |
| Өмнөх гэрээ дүгнэлтийн байдал | | | |
| Өмнөх гэрээний биелэлтээр илэрч байсан зөрчлүүд | | 2023 оноос хариуцан ажилсан гэрээ анх удаа дүгнүүлж байгаа. | |
| Өмнөх зөрчлийг арилгасан байдал | | Зөрчилгүй. | |

2. Дүгнүүлэх үзүүлэлт

| № | Хууль, тогтоомж, дүрэм, журам стандартын нэр зүйл заалт | Үзүүлэлтүүд | Тайлбар /хувь/ |
|---|---|---|---|
| 1 | ГТХ 35.1.1 ХБТХ 24.1.3 | Газраа зориулалтын дагуу ашиглаж байгаа байдал / 100%/ | Тийм **(100%)** |
| 2 | ГТХ 34.2 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэсэн эсэх / 100% / | 2023 онд БОННҮ "Эко натур" ХХК-аар хийлгэсэн 2028 онд хугацаа дуусна. **(100%)** |
| 3 | ГТХ 58.5 | Газрын төлөв байдал, Чанарын улсын хянан баталгаа хийлгэсэн эсэх /100 %/ | Газрын төлөв байдал чанарын хянан баталгааг хийлгэх **(0%)** |
| 4 | ГТХ 27.1, 27,4 | Газрын эргэлтийн цэг / солбицол/-ийг актаар хүлээн авсан байдал, дүр мэдэн өөрчилсөн /100%/ | Анх 2015 онд газар ашиглах гэрчилгээ авсан 2022 онд газрын хэмжээг нэмэгдүүлж цэг сольболцол өөрчилсөн. **(100%)** |
| 5 | ГАГ 5.12 | Стандартын бус ариун цэврийн байгууламж барьж, хөрс, ус бохирдуулсан эсэх /100%/ | Боловсон нойл 50 тн бохирын енкустай "Бор согоот"ХХК гэрээ байгуулан соруулдаг. **(100%)** |
| 6 | ГАГ 5.12 | Зөвшөөрөгдсөн талбайн хэмжээнээс хэтрүүлэн газар ашиглах, орц, гарц хаах, хашаа барих, | Байхгүй **(100%)** |
| 7 | ГТХ 35.3.3 | Газрын төлбөрийг цаг хугацаанд нь төлсөн байдал /100%/ | Цаг хугацаандаа тогтмол төлдөг. **(100%)** |
| 8 | ГАГ 5.12 | Ашиглаж байгаа газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад дамжуулан ашигласан эсэх | Байхгүй **(100%)** |
| 9 | ГАГ 5.13 | Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагатай байгуулан, төлбөрийг заасан хугацаанд бүрэн төлж барагдуулсан эсэх | Хөвсгөл аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар ус ашиглуулах дүгнэлтийн дагуу төлбөрийг төлж ажилдаг. **(100%)** |
| 10 | ГАГ 5.14 | Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан, мөрдөн ажилласан эсэх | Тийм Хатуу хог хаягдалыг "Бор согоот" ХХК гэрээ байгуулан тээвэрлэлтийг гэрээний хугацаанд хийсэн. **(100%)** |
| 11 | ГАГ 5.18 | Газар ашиглах гэрээг жил бүр дүгнүүлэхдээ тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээний төлөвлөгөө, түүнд зарцуулах хөрөнгө | 2023 онд БОННҮ, менежментийн төлөвлөгөөг "Эко натур" ХХК-аар хийлгэсэн 2028 онд хугацаа дууснa. Менежментийн төлөвлөгөөг мөрдөн ажиллаж байгаа. **(100%)** |
| 12 | ГАГ 5.21 | "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих төлөвлөгөөний дагуу мод тарьж, жил бүрийн үйл ажиллагааны тайланд үр дүнг тайлагнан дүгнүүлэх | 2023 онд Хөвсгөлийн УТХГ хамгаалалтын захиргааны ойжуулалтын талбайд 10 ширхэг мод тариулсан мөн 150,000 төгрөгөөр усалгаа арчилгааг хийсэн. **(100%)** |
| **Нийт хувь:** | | | **91.6 %** |
| Дүгнэлт, цаашид авах арга хэмжээ | | | Газрын төлөв байдал, Чанарын улсын хянан баталгаа хийлгэх |

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

| **Хянасан:** | Хүлээн зөвшөөрсөн: |
|---|---|
| Хөвсгөлийн УТХГ Хамгаалалтын захиргааны дарга ..................Б.Батбилгүүн /гарын үсэг/ / нэр/ | Газар ашиглагч: **"Бамбай секьюрити сервис" ХХК** |
| **Гэрээ дүгнэсэн:** Газар ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн: ..................Г.Амаржаргал /гарын үсэг/ / нэр/ | Менежер ..................../ Д.Дуламсүрэн/ /гарын үсэг/ /нэр/ |
| Аялал жуулчлал хариуцсан Ахлах мэргэжилтэн ..................Б.Амартүвшин /гарын үсэг/ / нэр/ | Утас: 8801-3329 |

**Гэрээ дүгнэлт 61%-иас дээш бол “Хангалттай”**
**Гэрээ дүгнэлт 60%-иас доош бол “Хангалтгүй”**

Зураг 31



ГОЛОМТ БАНК

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: GB122912202503211 | Татсан огноо: 2025-11-11 17:17

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| 2205010487<br>MN810015002205010487 | 1165117377<br>MN030015001165117377 | 147,923.00 MNT | Амжилттай |

Шилжүүлэгчийн нэр: БАМБАЙСЕКЬЮРИТИ СЕРВИС ХХК

Хүлээн авагчийн нэр: МТА.ТАТВАР

Гүйлгээний утга: 1250205024664;39900867150002;2587394;3990086715000

Хүлээн авагчийн банк: Голомт банк

Гүйлгээний огноо: 2025-03-21

ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан © Голомтбанк ХК.



ГОЛОМТ БАНК

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: GB128479202506021 | Татсан огноо: 2025-11-11 17:16

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| 2205010487<br>MN810015002205010487 | 1165117377<br>MN030015001165117377 | 147,923.00 MNT | Амжилттай |

Шилжүүлэгчийн нэр: БАМБАЙСЕКЬЮРИТИ СЕРВИС ХХК

Хүлээн авагчийн нэр: МТА.ТАТВАР

Гүйлгээний утга: 1250205026560;39900867150002;2587394;3990086715000

Хүлээн авагчийн банк: Голомт банк

Гүйлгээний огноо: 2025-06-02

ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан © Голомтбанк ХК.



ГОЛОМТ БАНК

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: GB90855202505081 | Татсан огноо: 2025-11-11 17:17

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| 2205010487<br>MN810015002205010487 | 1165117377<br>MN030015001165117377 | 147,923.00 MNT | Амжилттай |

Шилжүүлэгчийн нэр: БАМБАЙСЕКЬЮРИТИ СЕРВИС ХХК

Хүлээн авагчийн нэр: МТА.ТАТВАР

Гүйлгээний утга: 1250205025646;39900867150002;2587394;3990086715000

Хүлээн авагчийн банк: Голомт банк

Гүйлгээний огноо: 2025-05-08

ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан © Голомтбанк ХК.



ГОЛОМТ БАНК

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: GB128324202506021 | Татсан огноо: 2025-11-11 17:15

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| 2205010487<br>MN810015002205010487 | 1165117377<br>MN030015001165117377 | 133,333.00 MNT | Амжилттай |

Шилжүүлэгчийн нэр: БАМБАЙСЕКЬЮРИТИ СЕРВИС ХХК

Хүлээн авагчийн нэр: МТА.ТАТВАР

Гүйлгээний утга: 1250205027634;39900867150002;2587394;3990086715000

Хүлээн авагчийн банк: Голомт банк

Гүйлгээний огноо: 2025-06-02

ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан © Голомтбанк ХК.

Газрын төлбөр төлсөн баримтууд

# 7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

| № | БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | Хөвсгөл аймгийн БОАЖГ | Хяналт шалгалтын байгууллагын хяналтын хуудсаар | Төслийн бүхий л шатны үйл ажиллагааг | Хөвсгөл аймгийн “Байгаль орчин, аялал жуулчлалын газар”-ын мэргэжилтэн, Алаг-эрдэнэ сумын Засаг даргын тамгын газрын байгаль орчны байцаагч, ИТХ-ийн дарга, газрын байцаагч, татварын байцаагч, Хатгал тосгоны цагдаагийн тасгийн дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр хамтарсан багийн шалгалт бааз дээр хийгдсэн бөгөөд жуулчны баазын үйл ажиллагаанд шалгалт хийж, гурвалсан хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.<br>Хөвсгөл аймгийн Цагдаагийн газаартай хамтын ажиллагааны хүрээнд жуулчны бааз дээр камержуулалт хийж, нийт 6 цэг дээр, 9 камер тавьж, хулгай болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан. /Зураг 32, 33/ |
| 2 | Иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллагад | Уулзалт, танилцуулга зохион байгуулах | Төслийн танилцуулга, ерөнхий үйл ажиллагаа | Жуулчны бааз байршиж буй газрын орчимд амьдарч буй малчдын ахуй амьдралыг дэмжих зорилгоор малын мах, сүүг худалдан авч, амрагчид болон баазын ажилчдын хоол хүнсэнд нийлүүлдэг. Мөн Хатгал тосгонд зохиогддог наадмын үйл ажиллагаанд жил бүр хандив өргөдөг. /Зураг 34, 35/ |

Зураг 32

ГУРВАЛСАН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

№04
Он: 2025 сар: 07 өдөр: 02
Байрлал: [illegible] аймаг, [illegible] сум

1. Гэрээний Талууд:

1.1 Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)
Хаяг: [illegible]
Төлөөлж буй: [illegible] (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга – Б.Жанлав)
Цаашид "ИТХ" гэх

1.2 Цагдаагийн байгууллага
Хаяг:
Төлөөлж буй: [illegible] (Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч Ц.Жамбалдорж)
Цаашид "Цагдаагийн байгууллага" гэх

1.3 Жуулчны бааз (Аялал жуулчлалын байгууллага)
Нэр: [illegible]
Хаяг: [illegible]
Төлөөлж буй: [illegible] ( [illegible] )
Цаашид "Жуулчны бааз" гэх

2. Хууль эрх зүйн үндэслэл

Энэхүү гэрээг доорх хууль, журмыг үндэслэн талууд байгуулж байна. Үүнд:

**Монгол Улсын Үндсэн хууль**

- Иргэдийн аюулгүй байдал, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

**Аялал жуулчлалын тухай хууль**

- Жуулчны бааз нь аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна
- Жуулчдын аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах үүрэгтэй

**Зөрчлийн тухай хууль**

- Байгаль орчныг бохирдуулах, хог хаях, зөвшөөрөлгүй газар барилга барих зэрэг зөрчлийг зохицуулна
- Жуулчны баазын үйл ажиллагаанд зөрчил илэрсэн тохиолдолд хуулийн дагуу хариуцлага тооцно

**Байгаль орчныг хамгаалах тухай хууль**

- Байгалийн нөөцийг зөв зохистой ашиглах
- Байгальд ээлтэй үйл ажиллагаа эрхлэх, хог хаягдлын менежмент хийх

**Хөдөлмөрийн тухай хууль**

- Орон нутгийн иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг тэгш боломжоор хангах
- Ажилчдыг гэрээний дагуу ажиллуулах

**Цагдаагийн албаны тухай хууль**

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- Аюулгүй байдлын зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авах

**Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль**

- Сумын ИТХ нь тухайн нутаг дэвсгэрт аж ахуйн үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулалт хийх эрхтэй

3. Гэрээний Зорилго

Жуулчны баазын үйл ажиллагаанд орон нутгийн хөгжлийг дэмжих, хууль сахиулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, байгаль хамгаалах, нийгмийн хариуцлагыг өндөрсгөх зорилгоор гурван талт хамтран ажиллах нөхцөл, үүргийг тодорхойлох.

4. Хамтын Ажиллагааны Үндсэн Чиглэл

- Аялал жуулчлалын үйл ажиллагаанд хууль, журам мөрдүүлэх
- Жуулчдын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх ажилд хамтран оролцох
- Байгаль орчныг хамгаалах, хог хаягдалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- Орон нутгийн иргэдийг ажилд авах, орон нутгийн бүтээгдэхүүн хэрэглээг дэмжих
- Зөрчил, гомдол, ослын талаарх мэдээллийг харилцан шуурхай солилцох

5. Талуудын Үүрэг - ИТХ:

- Орон нутгийн бодлого, дэмжлэг, зохицуулалтыг хэрэгжүүлэх
- Иргэдийн санал, гомдлыг хүлээн авч зохих байгууллагад шилжүүлэх
- Жуулчны баазын нийгмийн хариуцлагын биелэлтэд хяналт тавих

**Цагдаагийн байгууллага:**

- Жуулчны бааз орчмын аюулгүй байдлыг хангах
- Зөрчлийг урьдчилан сэргийлэх, хяналт тавих, таслан зогсоох
- Хууль бус үйл ажиллагаанд хариуцлага тооцох

**Жуулчны бааз:**

- Үйл ажиллагаагаа хууль, дүрэм журмын дагуу явуулах
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, тогтвортой аялал жуулчлал эрхлэх
- Жуулчдад аюулгүй байдлын зөвлөгөө өгөх, бүртгэл хөтлөх
- Орон нутгийн иргэдийг дэмжих
- Жуулчний баазууд камержуулалт орчиноо харах бүрэн стандартад нийцсэн камерыг байршуулах
- Гадаад болон дотоодын жуулчидад Монгол/Англи хэл дээр тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гарын материал болон самбар байршуулсан байх
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх

6. Мэдээлэл солилцоо

Талууд хоорондоо дараах тохиолдолд мэдээлэл солилцоно:

- Ослын тохиолдол
- Зөрчил, гомдол
- Хууль бус үйлдэл, зөрчил илэрсэн тохиолдол
- Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажил

7. Гэрээний Хүчинтэй хугацаа

Гэрээ нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн **1 (нэг)** жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд талуудын харилцан зөвшилцлөөр сунгаж болно.

8. Маргаан шийдвэрлэх

Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргааныг харьяа сум, аймгийн түвшинд эв зүйгээр шийдвэрлэх бөгөөд боломжгүй тохиолдолд холбогдох шүүх байгууллагад хандана.

9. Хариуцлага

- Гэрээний аль нэг тал гэрээний заалтыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.
- Байгаль орчныг сүйтгэх, жуулчдын аюулгүй байдлыг хангаагүйгээс үүдэн гарсан хохирлыг буруутай этгээд барагдуулна.
- Талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзсан бол энэ талаар албан ёсоор мэдэгдэж, хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

10. Бусад

- Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж, гэрээний бүх талд адил хүчинтэй байна.
- Гэрээг өөрчлөх, нэмэлт оруулах бол гурван талын зөвшилцлөөр бичгээр хийнэ.

ГАРЫН ҮСЭГ:

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА [signature] /Б.ЖАНЛАВ/

ЦАГДААГИЙН ТАСГИЙН ДАРГА, ЦАГДААГИЙН ХОШУУЧ [signature] /Ц.ЖАМБАЛДОРЖ/

ЖУУЛЧНЫ БААЗЫН ЗАХИРАЛ [signature]

GREAT SEA TOUR LLC

Зураг 33



Зураг 34



“Грэйт си тур” ХХК - 6258727

**Бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдөл**

1. Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: Цогтоо Наранбаяр
2. Ажиллаж байгаа салбар хэсгийн нэр:
3. Албан тушаал: Малчин
4. Регистрийн дугаар: РХ 80052314
5. Холбоо барих утасны дугаар: 91383096
6. Оршин суугаа хаяг: Хөвсгөл аймаг Алаг-Эрдэнэ сум Хөтгөл тосгон
7. Зарлагын зориулал: Амралтанд нийлүүлсэн сүүний үнэ
65,000 (7.7-нд 10л сүү × 5000 = 50,000 сүү + тараг 15000)
215,000 (7.18-нд 40л сүү × 5000 = 200,000 + тараг 15000)
320,000 (8.01-нд 50л сүү × 5000 = 250,000 + тараг 70000)
8. Мөнгөний нэгж, хэмжээ /тоогоор/ 600,000 /үсгээр/ Зургаан зуун мянган төгрөг
9. Он, сар, өдөр: 2025.8.1 Гарын үсэг:
10. Ерөнхий санхүүчийн шийдвэр, гарын үсэг:
   - Мөнгө хүсэгчийн овог нэр:
   - ТТ-н нэр, регистр:
   - Захиалсан салбар:
   - Гүйлгээний утга:
   - Харьцсан данс:
   - Мөнгөний тоо, хэмжээ:
   - Суутгах татварын хувь, хэмжээ:
   - Олговол зохих дүн:
   - Зөвшөөрсөн огноо, гарын үсэг:
11. Захирлын шийдвэр, гарын үсэг:

12. Мөнгө олгосон няравын тэмдэглэл

12.1 Олгосон мөнгөний хэмжээ тоо, үсгээр: 600,000 (Зургаан зуун мянган төгрөг)
12.2 Няравын гарын үсэг:
12.3 Хүлээн авсан хүний гарын үсэг:
12.4 Хүлээн авсан он, сар, өдөр: 2025.8.1



“Грэйт си тур” ХХК - 6258727

**Бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдөл**

1. Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: Танхуяа Батбаяр
2. Ажиллаж байгаа салбар хэсгийн нэр:
3. Албан тушаал: Малчин
4. Регистрийн дугаар: РХ83022610
5. Холбоо барих утасны дугаар: 89919659
6. Оршин суугаа хаяг: Хөтгөл жанхайн ам
7. Зарлагын зориулал: Амралтын гал тогоонд хэрэгцээнд нийлүүлсэн махны үнэ (үхрийн)
(248,580 кг × 15000 = 3,728,700)
(VII/01-нд 500,000 + VII/24 3,228,700)
8. Мөнгөний нэгж, хэмжээ /тоогоор/ 3,728,700 /үсгээр/ Гурван сая долоон зуун хорин найман мянга долоон зуун төгрөг
9. Он, сар, өдөр: Гарын үсэг:
10. Ерөнхий санхүүчийн шийдвэр, гарын үсэг:
   - Мөнгө хүсэгчийн овог нэр:
   - ТТ-н нэр, регистр:
   - Захиалсан салбар:
   - Гүйлгээний утга:
   - Харьцсан данс:
   - Мөнгөний тоо, хэмжээ:
   - Суутгах татварын хувь, хэмжээ:
   - Олговол зохих дүн:
   - Зөвшөөрсөн огноо, гарын үсэг:
11. Захирлын шийдвэр, гарын үсэг:

12. Мөнгө олгосон няравын тэмдэглэл

12.1 Олгосон мөнгөний хэмжээ тоо, үсгээр: 3,728,700 (Гурван сая долоон зуун хорин найман мянга долоон зуун төгрөг)
12.2 Няравын гарын үсэг:
12.3 Хүлээн авсан хүний гарын үсэг:
12.4 Хүлээн авсан он, сар, өдөр: 2025.7.24

Зураг 35



Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

**БЭЛЭН МӨНГӨНИЙ ОРЛОГЫН БАРИМТ**

Дугаар 2025 он 07 сар 02 өдөр

Байгууллагын нэр ЗАА (хүлээн авсан)

Мөнгө тушаагч “Грэйт Си” ажилтан Д. овогтой Дуламсүрэн -нээс

Гүйлгээний утга Нэгдсэн хогийн 5098109521 Б. Долгорсүрэн

Тушаасан мөнгөний дүн 100,0 төгрөг мөнгө

Хавсаргасан баримт

Тэмдэг

Дарга
Нягтлан бодогч
Хүлээн авсан
Мөнгө тушаагч

## БОМТ-ний хүрээнд гарсан зардал

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төлөвлөгдсөн зардал мян.төг | Зарцуулсан мөнгөн дүн мян.төг |
|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал | 618.0 | 1220.0 |
| 2 | Орчны тохижилт, нөхөн сэргээлт | 750.0 | 4559.0 |
| 3 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - | - |
| 4 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 1984.0 | 4500.0 |
| 5 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 240.0 | 112.2 |
| 6 | БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ | 2300.0 | 591.7 |
| 7 | БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах | 500.0 | 4428.7 |
| **БОМТ-ний нийт зардал** | | **6392.0** | **15411.6** |

Зураг 36

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-27 тоот тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТАГ ДЭВСГЭРТ ГАЗАР АШИГЛАХ

# ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 2015/740

"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" Монгол улсын хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газраас Хөвсгөл аймаг /хот/ Алаг-эрдэнэ сум /дүүрэг/-ийн нутагт орших Хөвсгөл БЦГ тусгай хамгаалалттай газар нутгийн Жанхайн давааны ард нэртэй 2,0 га га талбайг Аялал жуулчлал зорилгоор ашиглахыг "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуульд заасан нөхцөл, журмын дагуу зөвшөөрч, энэхүү гэрчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 2587394,0 тоот гэрчилгээ /регистр/-тэй Бамбай секьюрити ХХК -д Тав жилийн хугацаагаар олгов.

Энэхүү гэрчилгээ нь газар ашиглалтанд оруулсан аливаа өөрчлөлт, сунгалтыг тэмдэглэх хавсралттай бөгөөд хавсралтгүй бол хүчин төгөлдөрт тооцогдохгүй.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Ч.БАТСАНСАР

2016 оны 1 сарын 15 өдөр

УХА0017 9085084

0150740

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ГАЗАР АШИГЛАХ
2015/740 ТООТ ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ
/Гэрчилгээгүй бол хүчингүй/

Хоёр. Гэрчилгээгээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлын өөрчлөлтүүд

| № | Солбицол, өөрчлөгдөх үндэслэл | Өөрчлөгдсөн солбицлууд |
|---|---|---|
| 1. | Талбайн анхны солбицлууд:<br>1 100° 9' 38.640" E 50° 34' 45.015" N<br>2 100° 9' 37.167" E 50° 34' 46.904" N<br>3 100° 9' 50.160" E 50° 34' 48.859" N<br>4 100° 9' 51.287" E 50° 34' 46.077" N<br>19433.5 квадрат метр<br><br>Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/433 дугаар тушаалыг үндэслэв.<br><br>ТХНУГ-ын дарга: Ч.Батсансар<br>2016 оны 01 сарын 15 өдөр<br>УХА0017 9085084<br><br>**Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/368 тушаал, Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 48 тоот саналыг тус тус үндэслэн газар ашиглах эрхийг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл сунгав.**<br><br>**2021 оны 11 дүгээр сарын 30 өдөр**<br><br>**ТХБНУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.БАТМӨНХ** | Талбайн өөрчлөгдсөн солбицлууд:<br>1 100° 9' 38.425" E 50° 34' 44.658" N<br>2 100° 9' 37.126" E 50° 34' 46.923" N<br>3 100° 9' 48.902" E 50° 34' 48.601" N<br>4 100° 9' 51.782" E 50° 34' 49.966" N<br>5 100° 9' 52.442" E 50° 34' 46.571" N<br>6 100° 9' 54.026" E 50° 34' 41.518" N<br>7 100° 9' 51.733" E 50° 34' 41.790" N<br>8 100° 9' 48.562" E 50° 34' 42.394" N<br>9 100° 9' 46.966" E 50° 34' 43.232" N<br>10 100° 9' 46.484" E 50° 34' 45.333" N<br>11 100° 9' 42.332" E 50° 34' 45.104" N<br>39459.28 квадрат метр<br><br>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн А/341 дүгээр тушаал, Хамгаалалтын захиргааны 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн № 164 тоот саналыг тус тус үндэслэн эргэлтийн цэгт өөрчлөлт оруулав.<br><br>2022 оны 09 сарын 06-ны өдөр<br>Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн дарга: Н.БАТЗАЯА<br><br>2022 оны 09 сарын 06-ны өдөр<br>Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн мэргэжилтэн: Э.ЭРДЭНЭХҮҮ |